

ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНУУДЫН АВЛИГЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ХАНДЛАГЫН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН

Ч. Должинсүрэн

Доктор (Ph. D.), дэд профессор

Нийгэм, хүмүүнлэгийн сургууль

Шинжлэх ухаан, технологийн их сургууль

0009-0004-1174-4221

DOI: 10.66753/

doljinsuren012@must.edu.mn

С. Ариунцэцэг

Докторант

Нийгэм, хүмүүнлэгийн сургууль

Шинжлэх ухаан, технологийн их сургууль

0009-0009-8294-1691

DOI: 10.66753/

ariuntsetsegsukhbat@gmail.com

Хураангуй: Энэхүү судалгааны зорилго нь их, дээд сургуулийн оюутнуудын авлигын талаарх ойлголт, хандлага, туршилага болон авлигад өртөх эрсдэлтэй орчныг тодорхойлоход оршино. Судалгаанд 18-аас дээш насны улсын болон хувийн хэвилийн их дээд сургуулийн 200 оюутан хамрагдсан бөгөөд тоон судалгааг асуумжийн аргаар, чанарын судалгааг ярилцлагын аргаар гүйцэтгэв. Судалгааны үр дүнгээс харахад оюутнуудын 81.2% нь авлигыг Монгол Улсад нийтлэг үзэгдэл болсон гэж үзсэн бол 72.5% нь авлигыг хүлээн зөвшөөрөхгүй гэж хариулсан байна. Энэ нь оюутнууд авлигыг ёс зүйн хувьд сөрөг үзэгдэл гэж үзэж байгаа ч бодит нөхцөлд асуудал шийдвэрлэх арга хэрэгсэл гэж хүлээн зөвшөөрөх хоёрдмол хандлага байгааг харуулж байна. Оюутнууд авлигыг зөвхөн мөнгөн хэлбэрээр бус танил тал, нөлөөлөл, эрх мэдлийн давуу байдлыг ашиглах хэлбэрээр өргөн хүрээнд ойлгож байв. Судалгаанд оролцогчдын 17.4% нь сүүлийн 12 сарын хугацаанд өөрөө болон гэр бүлийн гишүүн нь авлига өгсөн гэж хариулсан бөгөөд тэдгээрийн дийлэнх нь “шаардсан учраас өгсөн” гэж тайлбарласан. Авлига өгсөн оролцогчдын 36% нь шууд шаардсан, 64 % нь шууд бусаар ойлгуулсан гэж хариулсан нь авлига нь хувь хүний санаачилгаас илүүтэй байгууллагын хүнд суртал, шат дамжлага, мэдээллийн тодорхой бус байдлаас үүдэлтэй болохыг илтгэж байна. Авлигад өртөх эрсдэл хамгийн өндөр орчныг оюутнууд боловсролын байгууллага, төрийн үйлчилгээний байгууллага, эрүүл мэндийн байгууллага гэж үзсэн бөгөөд ялангуяа тэтгэлэг, дотуур байр, шалгалт, дүн үнэлгээ, тодорхойлолттой холбоотой үйлчилгээнд авлигын эрсдэл өндөр байгааг онцолсон. Судалгааны үр дүн нь оюутны орчин дахь авлигын эрсдэлийг бууруулахад авлигын эсрэг боловсрол, ёс зүйн төлөвшил, ил тод хяналтын тогтолцоо, шударга үнэлгээний механизм, аюулгүй мэдээлэх сувгийг бэхжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Түлхүүр үг: авлига, оюутан, ойлголт, хандлага, авлигын эрсдэл, их сургууль

УДИРТГАЛ

Монгол Улсад авлигын эсрэг хууль эрх зүйн орчин бүрдсэн, авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий бие даасан байгууллага ажилладаг бөгөөд авлигын түвшин, нөлөөллийг тодорхойлох судалгаа, үнэлгээнүүд тогтмол хийгддэг. Тухайлбал, авлигын төсөөллийн индекс, олон нийтийн ойлголт мэдлэгийн судалгаа, төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ зэрэг нь авлигын нөхцөл байдлыг ерөнхий түвшинд тодорхойлдог. Гэвч залуучууд, тэр дундаа оюутнуудын авлигын талаарх ойлголт, хандлага, туршлагыг тусгайлан авч үзсэн судалгаа харьцангуй хомс байна.

Оюутан залуус нь нийгмийн идэвхтэй бүлэг бөгөөд ирээдүйн мэргэжилтэн, төрийн болон хувийн хэвшлийн ажиллах хүчний гол нөөц болдог. Тэдний үнэт зүйл, ёс зүйн хандлага, авлигын талаарх ойлголт нь ирээдүйн нийгмийн шударга ёс, байгууллагын соёлд шууд нөлөө үзүүлэх ач холбогдолтой. Иймээс оюутнуудын авлигын талаарх ойлголт, хандлагыг судлах нь авлигаас урьдчилан сэргийлэх боловсрол, ёс зүйн төлөвшил, иргэний оролцоог дэмжихэд чухал ач холбогдолтой юм.

ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Авлига нь нийтийн эрх ашигт харшлан албан тушаал, эрх мэдлээ хувийн ашиг сонирхолд ашиглах үйлдэл бөгөөд зөвхөн мөнгө, эд материалын хэлбэрээр бус эрх мэдэл, нөлөөлөл, танил тал, давуу байдлыг ашиглан хууль, журам, шударга зарчмыг зөрчих бүхий л хэлбэрийг хамарсан нийгмийн сөрөг үзэгдэл юм. Авлигын тухай ойлголтыг олон улсын болон үндэсний түвшинд хууль эрх зүй, ёс зүй, нийгмийн шинжлэх ухааны хүрээнд олон талаас нь тодорхойлж ирсэн байдаг.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенцод авлигад хээл хахууль, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хууль бусаар хөрөнгөжих, нийтийн өмч хөрөнгийг завших зэрэг үйлдлүүдийг хамруулан авч үзсэн бөгөөд авлигыг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хүрээнд илэрч болох өргөн хүрээний үзэгдэл гэж тодорхойлсон байдаг. Энэ нь авлигыг зөвхөн хувь хүний ёс суртахууны доголдол бус институцийн гажуудал, хяналтын сул тогтолцоотой холбоотой үзэгдэл болохыг харуулдаг.

Монгол Улсын Авлигын эсрэг хуульд авлигыг “албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж өөртөө болон бусдад давуу байдал бий болгох, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус ашиг хүртэх” үйлдэл гэж тодорхойлсон байдаг. Энэхүү тодорхойлолт нь авлигыг зөвхөн мөнгөн хэлбэрээр хязгаарлахгүйгээр албан тушаалын нөлөөлөл, танил тал, үйлчилгээний давуу байдал, шударга бус хуваарилалт зэрэг өргөн хүрээний хэлбэрээр авч үзэх боломжийг бүрдүүлдэг.

Нийгмийн шинжлэх ухаанд авлигыг төр, байгууллага, хувь хүний хоорондын эрх мэдлийн тэнцвэргүй байдал, нийгмийн шударга ёсны алдагдал, институцийн сул байдлын илрэл гэж үздэг. Авлига нь зөвхөн хууль зүйн зөрчил бус, нийгмийн итгэлцэл, шударга ёс, тэгш боломжийн зарчмыг алдагдуулдаг бүтэцлэг асуудал юм. Иймээс авлигыг хувь хүний буруу үйлдэл гэхээс илүү нийгмийн бүтэц, институцийн доголдол, үнэт зүйлийн зөрчилтэй холбон ойлгох нь чухал байдаг.

Авлигын талаарх ойлголт нь тухайн нийгмийн үнэт зүйл, ёс зүйн хэм хэмжээ, иргэдийн эрх зүйн мэдлэг, төрийн байгууллагад итгэх итгэлтэй нягт холбоотой байдаг. Иргэд авлигыг хэрхэн ойлгож, ямар нөхцөлд зөвтгөж, эсвэл үгүйсгэж буй нь тухайн нийгэм дэх авлигын соёл, хүлцэл, эсэргүүцлийн түвшнийг тодорхойлдог. Энэ утгаараа авлигын талаарх ойлголт, хандлага нь авлигын бодит түвшингээс дутахааргүй чухал үзүүлэлт болдог.

Оюутан залуусын хувьд авлигын талаарх ойлголт, хандлага нь тэдний ирээдүйн мэргэжлийн ёс зүй, иргэний ухамсар, нийгмийн оролцооны төлөвшилтэй шууд холбоотой. Их, дээд сургуулийн орчин нь зөвхөн мэдлэг олгох бус, үнэт зүйл, шударга ёс, хариуцлага, иргэний ёс зүй төлөвшүүлэх орчин байдаг. Иймээс оюутнуудын авлигын талаарх ойлголт, хандлагыг судлах нь зөвхөн нэг бүлгийн үзэл хандлагыг тодорхойлох бус, ирээдүйн нийгмийн институцийн соёл, шударга байдлын төлөвийг тодорхойлох онол, практикийн ач холбогдолтой юм. Судалгааны онолын хүрээнд авлигын талаарх ойлголтыг гурван түвшинд авч үзэж болно. Нэгдүгээрт, танин мэдэхүйн түвшинд авлигыг юу гэж ойлгож буй ойлголт; хоёрдугаарт, үнэлэмжийн түвшинд авлигад хэрхэн хандаж буй хандлага; гуравдугаарт, зан үйлийн түвшинд авлигад оролцох, эсэргүүцэх, зөвтгөх эсэх бодит үйлдэл юм. Энэхүү гурван түвшин нь авлигын талаарх хувь хүний ойлголт, хандлагыг цогцоор нь тайлбарлах онолын үндэс болдог. Иймд авлигын талаарх ойлголт, хандлагыг судлахдаа авлигыг зөвхөн хууль зүйн зөрчил төдий бус, ёс зүй, үнэт зүйл, нийгмийн шударга ёс, институцийн соёлын асуудал хэмээн өргөн хүрээнд авч үзэх нь зүйтэй. Энэ хандлага нь оюутнуудын авлигын талаарх ойлголт, хандлагыг илүү бодитой, нийгмийн нөхцөлтэй уялдуулан тайлбарлах боломжийг бүрдүүлнэ.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Энэхүү судалгааны зорилго нь оюутнуудын авлигын талаарх ойлголт, хандлага тэдний амьдралд үзүүлж буй үр нөлөөг тодорхойлоход оршино.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд Улаанбаатар хотын улсын болон хувийн хэвшлийн их, дээд сургуулийн 18-аас дээш насны 200 оюутан хамрагдсан. Судалгаанд оролцогчдын 61.3% нь эмэгтэй, 38.7% нь эрэгтэй байв. Насны хувьд дийлэнх нь 18–24 насны оюутнууд байсан бөгөөд 1–4 дүгээр дамжааны оюутнууд жигд оролцсон. Оролцогчдын 72.4% нь бакалаврын түвшний, 27.6% нь магистрын түвшний оюутнууд байв. Амьжиргааны эх үүсвэрийн хувьд 64.7% нь эцэг эх, асран хамгаалагчаасаа хамааралтай, 21.3% нь цагийн ажил эрхэлдэг, 14.0% нь тэтгэлэг болон бусад эх үүсвэрээс орлого олдог байна.

Судалгаанд оролцогчдын 81.2% нь авлигыг Монгол Улсад нийтлэг үзэгдэл болсон гэж үзсэн бол 72.5% нь авлигыг хүлээн зөвшөөрөхгүй гэж хариулсан байна. Энэ нь оюутнууд авлигыг нийгэмд өргөн тархсан асуудал гэж үзэж байгаа ч ёс зүйн хувьд сөрөг байр суурьтай байгааг харуулж байна. Авлигыг хэрхэн ойлгож байгааг тодруулахад ихэнх оюутнууд “ажлаа түргэтгэхийн тулд мөнгө, бэлэг өгөх”, “танил талаар асуудал шийдвэрлүүлэх”, “эрх мэдлээ хувийн ашиг сонирхолд ашиглах” зэрэг хэлбэрээр ойлгож байв. Энэ нь оюутнууд авлигыг зөвхөн мөнгөн хэлбэрээр бус, танил тал, нөлөөлөл, давуу байдал ашиглах хэлбэрээр өргөн хүрээнд ойлгож байгааг харуулж байна.


Авлигад хандах хандлага

Оюутнуудын 72.5% нь авлигыг хүлээн зөвшөөрөхгүй гэж хариулсан боловч тодорхой нөхцөлд авлигыг “асуудал шийдвэрлэх арга” гэж үзэх хандлага ажиглагдсан. Тухайлбал, “авлига нь хүнд суртлыг шийдвэрлэх арга зам болдог” гэсэнтэй 26.8% нь санал нийлж, 58.4% нь санал нийлэхгүй, 14.8% нь мэдэхгүй гэж хариулсан байна. Мөн “авлига шударга бус дүрэм журмыг тойрч гарахад тусалдаг” гэсэнтэй 31.6% нь санал нийлж, 46.2% нь санал нийлэхгүй, 22.2% нь мэдэхгүй гэж хариулжээ. Энэ нь оюутнууд авлигыг зарчмын хувьд буруу гэж үздэг ч бодит нөхцөлд “үр дүнтэй хэрэгсэл” гэж хүлээн зөвшөөрөх хоёрдмол хандлага байгааг илтгэж байна. “Авлигыг бууруулахад иргэд өөрсдөө хариуцлагатай байх ёстой” гэсэн байр суурийг 74.3% нь дэмжсэн бол 12.6% нь дэмжээгүй, 13.1% нь мэдэхгүй гэж хариулсан байна. Энэ нь оюутнуудын дунд иргэний оролцоо, хариуцлагын талаарх ойлголт харьцангуй өндөр байгааг харуулж байна.

Авлигатай холбоотой туршилага

Судалгаанд оролцогчдын 18.7% нь өөрт болон гэр бүлийн хэн нэгэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхийн тулд авлига өгч болно гэж үзсэн бол 81.3% нь өгөхгүй гэж хариулсан байна. Сүүлийн 12 сарын хугацаанд судалгаанд оролцогч өөрөө болон гэр бүлийн гишүүн нь авлига, хээл хахууль өгсөн эсэхийг тодруулахад 17.4% нь өгсөн, 49.6% нь өгөөгүй, 18.3% нь мэдэхгүй, 14.7% нь хариулахаас татгалзсан байна.

Авлигын талаарх мэдээллийн эх сурвалж




Авлига өгсөн гэж хариулсан оролцогчдын ихэнх нь “шууд болон далд байдлаар ойлгуулсан учраас өгсөн” гэж хариулсан бөгөөд өөрийн санаачилгаар өгсөн тохиолдол цөөн байв. Үүнээс 64% нь шууд шаардсан, 36% нь “олон шат дамжлага”, “удаан хүлээлт”, “танил тал хэрэгтэй” гэх байдлаар шууд бусаар ойлгуулсан гэж хариулсан. Эдгээр авлига өгсөн оюутнуудын 49% нь багш, сургалтын албаны ажилтанд, 31% нь дотуур байр, оюутны үйлчилгээ хариуцсан ажилтанд, 20% нь төрийн үйлчилгээний байгууллагын ажилтанд өгсөн байна. Албан тушаалын хувьд 88.4% нь дунд шатны буюу мэргэжилтэн, ажилтанд, 11.6% нь удирдах түвшний албан тушаалтанд өгчээ.

Судалгааны явцад их, дээд сургуулийн оюутнуудаас төлөөлөн ярилцлага авсан. Ярилцлагын үеэр оюутнуудын дийлэнх нь сургуулийн сургалтын үйлчилгээ, дотуур байр, тэтгэлэг, шалгалт, үнэлгээтэй холбоотой үйл явцад авлигын эрсдэл хамгийн өндөр байдаг гэж үзсэн. Ялангуяа төрийн өмчийн их, дээд сургуулиудад энэ асуудал илүү мэдрэгддэг бөгөөд хувийн сургуулийн оюутнуудын хувьд сургалтын төлбөр өндөр боловч үйлчилгээний шат дамжлага харьцангуй бага тул авлигын дарамтыг төдийлөн мэдрдэггүй гэж тайлбарлав. Харин төрийн сургуулийн оюутнууд дотуур байр, тэтгэлэг, сургалтын тодорхойлолт, зарим тохиолдолд шалгалт, үнэлгээтэй холбоотой асуудалд илүү их хүндрэлтэй тулгардаг гэж үзжээ. Оюутнуудад зориулсан үйлчилгээ, тухайлбал тэтгэлэг, дотуур байр, тодорхойлолт, сургалтын үйлчилгээг авахад заавал авлига өгөх шаардлага байхгүй ч шат дамжлага, хүнд суртал, мэдээллийн тодорхой бус байдал их байдаг нь авлигын эрсдэлийг нэмэгдүүлдэг гэж ярилцлагад оролцогчид онцолсон.

Авлигад зарцуулсан мөнгөн дүнгийн хувьд ихэнх тохиолдолд 50,000-300,000 төгрөгийн хооронд хүртэлх мөнгө зарцуулсан байна. Үүний дийлэнх нь буюу 79% нь бэлэг, хоол, үйлчилгээ, үлдсэн хэсэг нь бэлэн мөнгө эд материаллаг хэлбэрээр өгөгджээ. Авлигыг гүйцэтгэх замын хувьд 64% нь танил талаараа дамжуулан өгсөн бол 26% нь өөрийн биеэр өгсөн гэж хариулсан байна. Ярилцлагын үед зарим оюутнууд “танил талгүй бол дотуур байр авахад хүндрэлтэй”, “тэтгэлэг, хөтөлбөрт хамрагдахад шударга бус байдал ажиглагддаг”, “зарим тохиолдолд багшид бэлэг өгөх нь хэвийн үзэгдэл мэт ойлгогддог” хэмээн дурдсан байна.

Оюутнуудын 58.6% нь авлигын талаарх мэдээллийг сошиал медиагаас, 7.4% нь телевизээс, 18.2% нь найз нөхөд, ам дамжсан ярианаас, 15.8% нь хичээл, сургалт, эрдэм шинжилгээний эх сурвалжаас авдаг гэж хариулсан байна. Оюутнуудын хувьд сошиал медиа, цахим орчин нь авлигын талаарх ойлголт, хандлагыг бүрдүүлэхэд илүү хүчтэй нөлөөлж байна. Нийт хүн амын хувьд телевиз, радио зэрэг уламжлалт мэдээллийн хэрэгсэл давамгайл хэвээр байна. Иймээс авлигын эсрэг мэдээлэл, нөлөөллийн ажлыг зорилтот бүлгийн онцлогт нийцүүлэн хүргэх шаардлагатай бөгөөд оюутан залууст чиглэсэн мэдээлэл, соён гэгээрүүлэх ажлыг цахим орчин, сошиал платформд түлхүү суурилуулах нь илүү үр дүнтэй нь харагдаж байна.



Авлигатай тэмцэхийн тулд юу хийх ёстой вэ ?

35.5%	Төрийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах
23.3%	Авах арга хэмжээ, шийтгэлийг хатуу болгох
21.8%	Шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй ил тод болгох
14.1%	Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх
3.8%	Олон нийтийг авлигын эсрэг соён гэгээрүүлэх
1.5%	Бусад

Хувь хүний авлигатай холбоотой туршлага, авлига өгөх эсэх хандлагыг авч үзэхэд судалгаанд оролцсон оюутнуудын дийлэнх нь авлигын эсрэг хандлагатай байна. Өөрт болон гэр бүлийн хэн нэгэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхийн тулд авлига өгөх эсэх хандлагыг харахад 15.3% нь авлига өгнө гэж хариулсан бол 84.7% нь авлига өгөхгүй гэж хариулсан. Энэ нь оюутнуудын олонх нь авлигыг ёс зүйн хувьд хүлээн зөвшөөрөхгүй, эсэргүүцэх хандлагатай байгааг харуулж байгаа боловч тодорхой нөхцөлд бодит амьдралын хүндрэл, хүнд суртал, шударга бус байдлыг даван туулах хэрэгсэл болгон зөвтгөх эрсдэл байсаар байгааг мөн илтгэнэ. Иймээс оюутнуудын авлигад хандах хандлага нь зөвхөн хувь хүний ёс зүйн асуудал бус, боловсролын орчин дахь шударга байдал, институцийн ил тод байдал, үйлчилгээний хүртээмжтэй шууд холбоотой нийгмийн шинжтэй асуудал болох нь харагдаж байна.

ДҮГНЭЛТ

1. Оюутнууд авлигыг нийгэмд нийтлэг тархсан, сөрөг үзэгдэл гэж ойлгож байгаа ч тодорхой нөхцөлд асуудал шийдвэрлэх арга хэрэгсэл гэж үзэх хоёрдмол хандлага ажиглагдаж байна.

2. Оюутнуудын авлигын талаарх ойлголт нь зөвхөн мөнгөн хэлбэрээр хязгаарлагдахгүй бөгөөд танил тал, нөлөөлөл, эрх мэдлийн давуу байдлыг ашиглах хэлбэрийг мөн авлигын нэг хэлбэр гэж ойлгож байна.

3. Оюутнуудын авлигад өртөх эрсдэл хамгийн өндөр орчин нь боловсролын байгууллага, тухайлбал элсэлт, тэтгэлэг, дотуур байр, дүн үнэлгээтэй холбоотой үйл явц байна.

4. Оюутнууд авлигыг эсэргүүцэх хандлагатай боловч бодит нөхцөлд хүнд суртал, шударга бус тогтолцоог даван туулах арга гэж хүлээн зөвшөөрөх хандлага байсаар байна.

5. Иймд оюутны орчинд авлигын эсрэг боловсрол, ёс зүйн сургалт, шударга үнэлгээний тогтолцоо, мэдээлэх аюулгүй суваг, ил тод хяналтын механизмыг бэхжүүлэх шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

1. Heyneman, S. P. (2011). *The concern with corruption in higher education*. International Higher Education, 19(1), 12–14.

2. Johnston, M. (2005). *Syndromes of corruption: Wealth, power, and democracy*. Cambridge University Press.

3. Монгол Улс. (2006). *Авлигын эсрэг хууль*. Улаанбаатар, Монгол Улс.

4. Transparency International. (2023). *Corruption perceptions index 2023*. Transparency International.

5. United Nations. (2004). *United Nations Convention against Corruption*. United Nations.

6. *Авлигатай тэмцэх газар*. (2023). *Шударга байдлын үнэлгээний тайлан*. Улаанбаатар, Монгол Улс.